

## ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**КНР: КРАТКИЙ ИСТОРИЧЕСКИЙ ОЧЕРК  
(1949-1979 гг)****М. Политиздат, 1980- 206 с**

Мао Зэдуныг залгамжлагчид гадазд бодлогын салбарт дэлхийн дайн зайлшгүй бөгөөд намжмал байдлыг хорлон бусниулж, энх тайван дэвшил хөгжлийг саатуулж болно гэдэгт урьдын адил найдлага тавьж, социализмын эсрэг улигт чиг бодлогоо баримталсаар байна гэж «БНХАУ: Товч түүхэн найруулал (1949-1979)» номд өгүүлжээ.

Болгар, БНАГУ, ЗСБНХУ, Куба, Монгол, Польш, Чехословакийн хятадыг судлагч эрдэмтдийн хамтран туурвисан эл номыг Москва дахь улс төрийн ном зохиолын хэвлэлийн газар хэвлүүлсэн байна.

Энэ ном Хятадад ардын хувьсгал ялж БНХАУ байгуулагдсан үеэс хойших 30 жилийн дотор улс төр, нийгэм эдийн засгийн гол гол хувьсгалт өөрчлөлтийг онол, улс төр, үзэл суртлын гүнзгий дүгнэлттэй, товч тодорхой баримтад тулгуурлан харуулсан үндсэн найман бүлэг, удиртгал, төгсгөлөөс бүрдэж байна.

Өргөн олон уншигчдад зориулсан энэ номд БНХАУ байгуулагдсаны дараахи арваад жилийн улс төр, нийгэм эдийн засгийн хөгжлийн дэвшилт хандлага, ач холбогдлыг үнэлээд харин дараагийн 20 жилд уг хандлага ухралтанд орж, нийгэм эдийн засгийн хөгжил зогсонги байдалд шилжсэнийг тодорхой баримтаар өгүүлжээ.

Номд Хятадын гадаад бодлого хэрхэн империализмын эсрэг бодлогоос империалист харгис хүчтэй бүх талаар сүлбээлдэн хамсах бодлого болж өөрчлөгдсөн хувьслыг тодорхой харуулсан байна. Зохиогчид Бээжингийн эрх баригчдаас явуулж байгаа маоист харгис бодлого хятадын ард түмний язгуурын эрх ашгаар зогсохгүй, тэдний олон улсын талбар дахь жинхэнэ хань нөхдийн нь эрх ашигт ч эрс харшилж байгааг нотлон үзүүлсэн байна. Маогийн бүлэг 1950-иад оны дундаас хятадын ард түмэн бол «Цэвэр цагаан цаас», «Цэцэг бүхэн дэлгэрч, эрдэмтэн бүхэн уралдаг», «Долгион хөгжлийн тухай хууль» гэх мэт адал балмад томьёоллууд тавьсан нь БНХАУ-ыг шилж сонгосон шинжлэх ухааны социализмын замаас нь холбилох, түшиг тулгуур болсон дэлхийн социализм түү- ний дотор ЗХУ-аас хөндийрүүлэхэд чиглэсэн «онцгой чиг шугам» байсныг зохиогчид яруу тод харуулжээ.

«Их үсрэлт» гэгч эдийн засгийн алдаатай бодлого улс орны нийгэм эдийн засгийг эмх замбараагүй байдалд оруулсныг 1961 оны нэгдүгээр сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрт арга буюу хүлээн зөвшөөрөхөд хүрснийг зохиогчид цохон тэмдэглэжээ. Үүний зэрэгцээ Бээжингийнхэн социалист хамтын нөхөрлөлийн орнууд, юуны өмнө ЗХУ-ын эсрэг илэрхий өдөөн хатгасан үйл ажиллагаа явуулж, империализм, харгис хүчтэй ойртох явдлаа түргэвчлэн, тэдэнтэй хамсан дэлхийн социализм, коммунизм болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг «олон улсын нэн өргөн нэгдэл фронт» байгуулахыг эртнээс чармайж байсан ба одоо уг бодлогоо «олон улсын гэрээ хэлэлцээрийн систем болгох зорилго» тавьж байгааг энэ номд тодорхой өгүүлжээ. Өөрийн ор-

ны дотоодод ард түмний эсрэг, гадаадад социализм, энх тайван, олон улсын коммунист хөдөлгөөний эсрэг адал балмад ажил явууллагаа маогийнхан улам хурцатгасныг 1966-1969 онд явуулсан «соёлын хувьсгал» гэгчийн жишээгээр зохиолын VI бүлэгт тодорхой өгүүлжээ. «Пролетарийн соёлын их хувьсгал» нэрийн дор хувьсгалын эсэргүү эргэлт хийж, хятад орон даяар маогийн «цэрэг хүнд суртлын диктатур» тогтоосон нь хятад орныг социализмын замаас улам бүр холдуулж, эдийн засаг, улс төрийн амьдралын хувьд империалистуудад буулт хийхээс өөр замгүй<sup>1</sup> болгоход хүргэсэн байна. Маоист эрх баригчид империализмтай тал бүрийн холбоо сүлбээ тогтоох чиг бодлого баримталж «дөрвөн шинэчлэлт» гэгчээ хэрэгжүүлж, хятад улсыг милитарист гүрэн болгоход империалистууд, гадаадын капиталын тусламжинд дулдуйдаж байгаа нь БНХАУ-ын нийгмийн байгуулал цаашид төрөл арилжих, хятадын ард түмний социалист ололт бүрмөсөн алдагдах аюулыг хүчтэй болгож байна гэж уул номыг зохиогчид үзсэн нь 1964 онд МАХН-ын Төв Хорооноос ХКН-ын Төв Хороонд урьдчилан анхааруулж байсныг бүрэн нотолж байна.

Номыг зохиогчид хятадын удирдлагаас «соёлын хувьсгалаас» хойш явуулж буй гадаад, дотоод бодлогын адал балмад чиг шугамыг улс төрийн талаар гүнзгий дүгнэн үзээд Бээжингийн төрийн эрхийн төлөө тэмцэл эцсийн эцэст хятад орныг социализмаас улам бүр таслан холдуулж, их гүрний жанжлах санаархлаа хэрэгжүүлэх хүчирхэг гүрэн болгох маоист санаархалд нэгдэн нийлэх, арга барилын хувьд хоорондоо эрс ялгаатай бүлэглэлүүдийн нэг зорилготой тэмцэл гэдгийг онолын хувьд хөдөлбөргүй нотолж өгчээ.

Номын VIII бүлэгт Маогоос хойш түүнийг залгамжлагчид улс орныг нийгэм-эдийн засгийн хямралаас гаргах арга зам хайж, цэрэг зэвсгийн хойноос улайран хөөцөлдөж эл зорилгоо биелүүлэх үүднээс империалист харгис хүчтэй улам бүр сүлбээлдэн эдийн засаг, цэрэг улс төрийн хувьд тэдний мэдэлд атгагдаж, төрийн эрхийн тэмцэл, самуурал зогсолтгүй үргэлжлэн байгааг бодит баримтад тулгуурлан оновчтой тайлбарласан байна.

Хуа, Дэнгийн аль ч бүлэг төрийн дээд эрх барьсан «их гүрний жанжлах дээрэнгүй үзэлдээ, зөвлөлтийн эсрэг, түгшүүртэй байдлыг намжаахын эсрэг бодлогондоо маоизмыг аль болох оновчтой ашиглахыг эрмэлзсээр байх болно»(166-р тал) гэдэг нь тодорхой гэж зохиогчид дүгнэжээ.

Уул номыг зохиогч эрдэмтэд бээжингийн эрх барих бүлгээс олон улсын тавцанд явуулж байгаа гадаад улс төрийн бодлогыг дүгнэн бичихдээ хувьсгалт үг өгүүлбэрээр халхавч хийж, Марксизм-Ленинизм, пролетарийн интернационализмд үнэнч байгаа мэтээр мэдэгдэж, үнэн хэрэгтээ хувьсгалын эсрэг, коммунист байр суурины эсрэг дэлхийн хамгийн харгис хүчтэй бүх талаар ойртож, социализм, энх тайвны эсрэг явуулж байгаа тэмцлээр тэдний өнөөгийн байр суурь тодорхойлогдож байна гэжээ.

Энэ зохиол орчин үеийн дэлхий дахины дэвшилт бүх үйлсийг жадлан эсэргүүцэж байгаа Бээжингийн маоист эрх баригчдын гадаад дотоод улс төрийн бодлогын мөн чанарыг онолын үндэслэлтэй илчлэн няцааснаараа өргөн олон уншигчдад үнэтэй чухал бүтээл болсон байна.

**М. Зэнээ**

<sup>1</sup>МАХН-ын Төв Хорооноос ХКН-ын Төв Хороонд илгээсэн захидал.  
«Үнэн сонин. 1964 оны 7-р сарын 28.